Сум—нэгдлийн даргын албан тасалгаанд сумын хариуцлагатнууд цуглараад МАХН—ын Төв Хорооны бүгд хурал, аймгийн намын бүгд хурал, АДХ—ын чуулганыг угтаж 1964—1965 оны өвөлжилт төлийн бэлтгэлийг хангах өндөр бүтээлийн 15 хоногийн ажлыг газар дээр нь шалгаж дүгнэх төлөөлөгчдийг бригад суурь фермд томилж үүрэг даалгавар өгөв.

Нэгдлийн ерөнхий хорооны дарга Түдэв.

—За Намсрай миний алаг, Насанжаргалын шарга, энэ хүнд Мөрдэндэвийн цоохор морийг авчир. Эртхэн газар дөхөө гэв.

Үхрийн ферм орохоор дөрөө хавируулан элдвийг ярилцаж явав. Бидэнтэй хамт яваа нэгдлийн зоо—техникч залуу өнөөдөр чинь өвлийн эхэн сарын 16 шүү дээ тэхэд хүйтэрдэггүй яг л намар, өвөлжөөнд буух гэхээр усаар дутагдаад байдаг гээд урьд өдрийн орсон хутганы мөр хиртэй цас наранд хайлж буйг атаархсан мэт харна. Их бага Хөшгийн хөндий ухаа толгодоор зах нь харагдахгүй тариалангийн талбай шатарын хөлөг шиг алаглаж түүнийг тойрон өвс тэжээл дүнхийтэл хураасан хашаа саравчтай өвөлжөө энд тэндгүй харагдах нь фермийн хамт олны мал сүргээ онд тарган оруулах бэлтгэлийг цагийн аятайд хийсэн ажлын бүтээлийг илчлэх мэт. Манай нэгдэл 2753 га тариалангийн талбайтай энэ намар 1428 га—гаас үр тариа малын тэжээлийг хурааж улсад 250 тонн будаа төлөвлөгөөнөөс илүү тушаасан. Малын тэжээлд зориулж хушуу будаа 200 тонн, вандуй 41 тонн, эрдэнэшишийн дарш 60 тонн, сүрэл 2100 тонн, өвс 6200 тонныг нөөцөлсөн Аймгийн намын хорооны шийдвэрээр аймгийн төвийн хөдөлмөрчдийг сүү цагаан идээгээр үйлчлэх үнээний хоёр ферм байгуулах ёстой. Фермээ тарианыхаа талбай түшиглүүлж энд байгуулаад байгаа юм Одоогийн байдлаар 600 үнээ сааж байна.

2 фермийн 5 суурь 2 ээлжийн хашаа саравчтай тэр хойд энгэрээр байгаа хашаанд одоо буугаад 12 сарын сүүлчээр нүүж өвс тэжээл татсан өвөлжөөндөө бууж үнээгээ төллүүлэх юм гэж нэгдлийн дарга Түдэв ярив.

ДЭЛГЭРИЙН СУУРИЙНХАН ТҮРҮҮЛЖ ЯВНА

Бага хөшгийн энгэр дэх Дэлгэрийн суурийн өвөлжөөнд очтол хэдэн хүн өвс нуруулдаж өвөлжөө бууцаа засаж байв.



ЗУРАГ ДЭЭР: 10—р сарынхаа хүн км—ийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн 13 дугаар баазын жолооч Дагвадорж.

# *Авдархангай нэгдлээр явахад*

*(Тэмдэглэл)*

Суурийн ахлагч Дэлгэр гэдэг 50 эргэм насны шаравтар царайтай хүн барьсан ацаа тавьж духныхаа хөлсийг арчаад бидэнтэй мэндлэв.

—Тарган тавтай өвөлжиж байна уу? гэхэд.

Тарган сайхан л өвөлжиж байна. Цаг сайхан, мал ч намраараа байна.

Хашир хүн гэж хаширсан хүнийг хэлнэ гэгчээр тэнгэрийн сайханд тайвширч бэлтгэл хийлгүй байгаад хатуухан өвөлтэй тулгарч хэцүүхэн онд орж байсан удаа бий.

Түүнээс хойш л би хашир хүн болсон юмдаа. Манай суурийн 7 өрхийн 6 саальчин 200 гаруй үхэр маллаж, 108 үнээ саадаг.

Сууриараа өдөрт 110 литр сүү тушааж байна. 59 настай Х.Цэвээн, 63 настай Н Жарантай нар үнээ бүрээс 492—522 литр сүү сааж бусдаасаа түрүүлж байна.

Өвөлжөөгөө иймэрхүүл зассан.

Энд 100 тонн ногоон өвс, 400 тонн сүрэл 2 тонн хөх бууц хатсан гурилын хивэг, овъёос, улаан буудай, хужир зэрэг тэжээл 5 тонн гаруйг нөөцөлсөн, аргал түлш бэлэн.

Гэрийн буурь засаж, муу усны нүх бие засах байр бэлэн болсон, хашаа саравчны засвар гүйцсэн, үхэр тарган, бяруу тугал х[illegible] сайн таргалсан шүү, манай суурийн үхэр тэр байна очиж үзэхгүй юу гэж суурийн ахлагч Дэлгэр ярив.

ХУВИН ДҮҮРЭН СҮҮ

Сэргэлэн сумын ,,Авдархангай нэгдлийн" Санжаасүрэн, Бямбаа даргатай 1,2 дугаар фермийнхэнд үхрийн нутаг билчээр тэжээл маллагааг тохируулж үнээний сүү шимийг нэмэгдүүлдэг туршлагатай саальчид олон байна.

[illegible]7 жил үнээ сааж байгаа 1 дүгээр фермийн саальчин Лхам нутгийн монгол үүлдрийн 15 гунжнаас 715 литр сүү, 52 настай саальчин Дулам бүдүүн үнээ бүрээс 650 литр, 14 настай саал[illegible]н Маналжав 5 үнээ бүрээс 490 литр сүү сааж бахдам амжилт гаргаж байна.

Энэ фермүүдийн саальчид 1964 оны аймгийн аварга Мөнгөнморьт сумын саальчин Гиймаагийн үнээнд гурилын хивэг, овъёос өгдөг, хөдөлмөрийн баатар Авирмэдийн үнээнд төмс жигнэн тэжээж их сүү авдаг туршлагыг хэрэглэж байгаа нь сүүний гарцыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болж байна.

Үхрийн фермүүдийн суурь бүр өвөлжөөндөө 100 тонн ногоон өвс, 400—500 тонн сүрэл, 30 тонн хушуу будаа, 10 тонн вандуй, 12 тонн эрдэнэшишийн дарш 1 тонн манжин, 3 тонн төмс, [illegible]0—40 шуудай хивэг, 2—5 тонн бууц нөөцлөн авч хашаа саравчаа [illegible]лаалж бэлэн болгоод өнтэй тарган өвөлжиж байна

(Төгсгөл нь 4 дүгээр нүүрт)

# БҮТЭЭЛЧ АЖИЛ

Довдон ахлагчтай социалист хөдөлмөрийн төлөө бригад анх 1964 оны 8 дугаар сард эхлэн байгуулагджээ. Тус бригад 1965 оны 8 дугаар сар хүртэл 1 бүтэн жилийн хугацаатай үүрэг амлалт авч энэ хугацаанд сар бүрийнхээ тонн-км-ийн төлөвлөгөөг гишүүн бүр 150—200 хувиар биелүүлж байгаагаас гадна тус бригад авто тээвэрчдийн улсын анх дугаар зөвлөлгөөнийг угтаж 11 дүгээр сарын 11-нээс 25-ныг хүртэл өндөр бүтээлийн 14 хоногийн ажил зарлан явууллаа.

Өндөр бүтээлийн хугацаанд явахад бэрхтэй бартаат замд 2870 ширхэг гуалинг аж ахуйн төвд авчирах юмаа.

Сүүлийн 3 хоногт өдөрт 3 дахин нийт 77 удаа тээвэр хийж 1300 ширхэг гуалинг амжилттайгаар зөөвөрлөв.

Тус бригадын гишүүд сангийн аж ахуйн өмнө тавигдсан чухал асуудлыг биелүүлэхэд нэгэн санаа эрмэлзэлтэйгээр ажиллаж аймгийн намын бүгд хурал, АДХ-ын гүйцэтгэх захиргааныхаа чуулганд өндөр бүтээлийн амжилтаар бэлэг барих гэж зориг төгөлдөр ажиллаж байна.

*М Батмөнх*



ЗУРАГ ДЭЭР: Довдон ахлагчтай социалист хөдөлмөрийн төлөө бригадынхан Аймгийн намын хорооны 5 дугаар бүгд хурал, АДХ—ын 6 дахь удаагийн 6 дугаар чуулганыг угтаж хийх ажлаа зөвлөж байна.

**Энэ хоёр нүүрийг аймгийн намын хорооны 5 дугаар бүгд хурал,**

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

17 дахь жилдээ №90 (1395) | 1964 оны 11 дүгээр сарын 30 | ДАВАА

## Өвлийн отрыг сайн зохион байгуулъя

Байгалийн хатуу улиралд билчээрийн ургамалыг нарийн зохион байгуулалттай зөв ашиглах нь төрөл бүрийн малыг онд мэнд оруулахад чухал ач холбогдолтой

Өвлийн улиралд адуун сүрэг ба эр сувай үхэр, тэмээ бог малыг цас нимгэнтэй нөмөр нутагт зориуд зохион байгуулалттай оторлох нь малын тарга хүчийг тогтоох ба өвчин эмгэгээс сэргэмжлэх чухал арга юм.

Баян, Баянцагаан зэрэг сумдын зарим малчид өвлийн хатуу улиралд сүрэг сууриа сайн оторлож хаврын улиралд тарга хүчийг доройтуулдаггүй сайн туршлагатай билээ. Аймгийн намын хороо, АДХ—ын гүйцэтгэх захиргаа 1964—65 оны өвөл хаврын саруудад адууны оторлох үндсэн нутгийг Малахын тал, Сайн муу хөөт, Шархай, Жарангийн хөндий зэрэг газруудад оторлох хуваарь гаргасанаар Баянбараат, Баянцагаан, Баян, Баяндэлгэрийн адуу отort гараад байна.

Отoрт зөвхөн малыг сүрэглэж гаргасанаар отор зохиох ажил дуусаж байгаа биш отрын малыг усаар зутраахгүй, билчээрийг үрэгдүүлэхгүй байх өдрийн хариуллага ба шөнө манах ажлыг малчдын дунд нарийн графикаар зохиох ёстой.

Отрын малыг аль хугацаанд хаана байх тухай графикийг сангийн аж ахуйн захиргаа, нэгдлийн ерөнхий хороод батлаж гаргаж өгөх ёстой.

Оторлосон малыг ширүүн туух эсвэл хариуллагагүй уул тал хөндий тойромд холхиулан явуулахыг хатуу цээрлэх ёстой.

Үхэр ба бог малын хэд хэдэн суурийг тусгай даамал даргатай ажиллуулах буюу хэд хэдэн суурь адууг нэгтгэж тэднийг төвлөрсөн нэг газраас удирдаж хянаж байх ёстой.

Сангийн аж ахуй нэгдлийн удирдлага нам, олон нийтийн байгууллагууд оторчдын хооронд социалист уралдаан байгуулах тэргүүний малчдаар үүрэг илэрхийлэлт авахуулж тэдгээрийн туршлагыг сурталчилж байх хэрэгтэй.

Олон суурь мал оторлох газрын төвд отрын штаб байгуулж үүнд отрын даамал малын ба хүний эмч санитарч, худалдааны агент тогтмол ажиллуулан отрын малчдыг хэрэгцээт бараа эм соёлын үйлчилгээг хийлгэж байх хэрэгтэй. Отрын штаб нь оторчдын дунд яриа таниулга хийх, сонин хэвлэл түгээх, радио сонсгох ажлыг өргөн далайцтай зохиох ба мал, хүн эмнэлэг үйлчилгээний түргэн тусламжийг үзүүлж байх ёстой. Отрын штабын удирдлага нь өвс билчээрийн байдлыг тогтмол хугацаанд газар дээр нь шалгаж ашиглах ээлж хуваарийг сууриудад зааж өгч байх хэрэгтэй.

Отoрт яваа малчид төрөл бүрийн малын тарга хүчний байдал өвчин эмгэг, малын хорогдол зэргийн тайланг 10 хоног дутам гаргаж түүнийгээ, сангийн аж ахуй, нэгдлийн удирдлагад тогтмол мэдээлж байх.

Отрын малын эмч, зоо-техникч нар отрын байдлын тухай илтгэл мэдээг гаргаж байх ба өвчтэй малыг аль болохоор оторлож байгаа нутгий нь нэг хэсэгт төвлөрүүлж эмчлэн эдгэрүүлж байх зохион байгуулалт хийгдсэн байх ёстой. Отрын сайн муу талыг отoрт гарсан малчдын зөвлөлгөөнөөр 15 хоног дутам хэлэлцүүлж тэдний өмнө тодорхой үүрэг зорилтыг дэвшүүлэн тавьж байх ёстой. Зоо-техникч малын эмч нар оторлосон малын услалт хужирлалтыг нарийн тохируулах өвс ургамал цасны зузаан нимгэнийг хянаж сууриудын малын байр шилтийг зааж тогтоож байх хэрэгтэй.

Отoрт гарсан малын тарга хүчийг нэг бүрчлэн сар бүр үзэж зутарч ядарсан ба тэжээл шаардагдах хэсгийг тэжээх арга хэмжээг аж ахуйн удирдлагуудтай ярьж тэжээлд оруулж байх нь чухал. Бог малыг оторлоход өтгө бууц сайн ашиглах нь чухал бөгөөд дороос жиндэж даарч зутрах явдлаас болгоомжилж байх хэрэгтэй.

Өвлийн отрыг хичнээн сайн зохиож чадсанаар малын тарга хүчийг тогтоож чадах бөгөөд тарга хүчээ алдаагүй малын амьдын жин сайн, өвчин эмгэгт нэрвэгдэх нь бага байх учир отрын гол зорилго нь малын тарга хүчийг тогтоох явдал мөн тул энэ талаар тэргүүний хашир малчдын санал зөвлөлгөөнийг цаг ямагт авч малын хариуллагыг хамгийн сайн зохиож билчээрийн ургацыг дээд хэмжээгээр ашиглах явдал чухал.

Отoрт гарах малчдын орон сууцыг зориуд хангаж өгөх тэдний хоол хүнс, хувцас хунар, ус түлш зэргийг сангийн аж ахуй, нэгдлээс урьдчилан базааж хангах ёстой. Отрын ач холбогдол, малын тарга хүчийг тогтоох арга техникийг өргөн сурталчлах оторчидтой байнгын харилцаа холбоотой байх талаар сум тус бүрд нарийн журам тогтоох зэргээр мал оторлолтын ажлыг хамгийн сайн зохион явуулахад оршино.

## Үндсэн фонд, түүнийг бүрэн тоолж дахин үнэлэх зорилго

Нийгмийн хөгжлийн түүхэн явцад үйлдвэрлэлийн үндсэн махбодийн хэсэг болсон хөдөлмөрийн хэрэгсэл нь хүчний хөгжилд шийдвэрлэх ролийг гүйцэтгэсээр ирсэн байна.

Хөдөлмөрийн хэрэгслэлийн хөгжлийн хир хэмжээ нь тухайн нийгмийнхээ харилцаануудыг тодорхойлдог бөгөөд нийгмийн эдийн засгийн шатуудыг юу үйлдвэрлэж чаддагаар биш, харин хөдөлмөрийн ямар хэрэгслэлээр үйлдвэрлэж байгаагаар тодорхойлдог.

Ийм учир хөдөлмөрийн хэрэгслэл нь хүмүүст бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд туслагч төдийгүй нийгмийн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл мөн юмаа.

Улс ардын аж ахуйн салбаруудад хөдөлмөрийн хэрэгслэлийн хэмжээ, түүний байрлалт, хуваарлилтыг нарийн бүртгэн судлах, төлөвлөх нь эдийн засгийн бодит шаардлагуудын нэг болж ирлээ.

Хөдөлмөрийн хэрэгслэлийн практик амьдрал дахь биет байдал нь үйлдвэр аж ахуйн байгууллагуудын үндсэн хөрөнгө, нягтлан бодох бүртгэлд үнийн дүнгээр илэрхийлэгдсэнээр үндсэн фонд юмаа. Үндсэн фондонд хамаарагдаж орох зүйлүүд нь орон барилга байгууламж, дамжуулах байгууламж, хүчний машин тоноглол, ажлын машин тоноглол хэмжих ба тохируулах багаж хэрэгслэл байгууламж, багаж хэрэгслэл, үйлдвэрлэлийн ба аж ахуйн багаж зэвсэг, эд хогшил, ажлын ба үржил ашиг шимийн мал, шувуу зөгийн аж ахуй, тарьж суулгасан олон каст мод ургамал, газрын хөрс сайжруулалт, усан сангууд зэрэг юмаа. Үндсэн фондын тооллого, дахин үнэлэлтийг бүх үйлдвэр аж ахуйн байгууллагад явуулах бэлтгэл ажлыг хангах талаар 1964 оны 5 дугаар сард БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарч үндсэн хөрөнгийн нэгж барилга байламж, дамжуулах хэрэгслэл техник тоног төхөөрөмж нэг бүрийг паспорт, техникийн баримттай болгох ажил явагдаж байна.

Үндсэн фондын бүрэн тооллого, дахин үнэлэлт хийгдсэнээр адил төрлийн нэгж бүхэн ижлээр үнэлэгдэх, элэгдлийг тоног төхөөрөмжийн жинхэнэ хорогдох хэмжээгээр зөв тогтоох, ингэснээр элэгдлийн фонд байгуулагдаж бүтээгдэхүүний өөрийн өртөгт зөвөөр тусгагдана. Энэ бүхэн аж ахуйн ажиллагааны үр дүнг тодорхойлоход эдийн засгийн чухал ач холбогдолтой томоохон арга хэмжээний нэг мөн.

Улсын төлөвлөгөөний комисс, Сангийн яам, тоо бүртгэлийн төв газрын тогтоол ёсоор бүрэн тооллого, дахин үнэлэлтийн бэлтгэл болон зохиогдож байгаа үндсэн хөрөнгийн одоогийн тооллогыг хугацаанд нь чанартай явуулах явдал үйлдвэр, барилга, тээвэр холбоо, худалдаа, хөдөө аж ахуйн төсөвт бүх байгууллагын үндсэн үүрэг мөн.

Үндсэн фондын тооллого нь нарийн тогтоосон зааврын дагуу хийгдэх учиртай.

Үүнд бүх нягтлан бодогч нар, инженер, механикчдийг дүүрэн оролцуулж уг ажлыг шаардлагын дагуу хийх хэрэгтэй байна.

*Аймгийн тоо бүртгэлийн товчооны дарга Хаянхярваа*

## ТОВЧХОН МЭДЭЭ

МХЗЭ—ийн гишүүн Довдон ахлагчтай социалист хөдөлмөрийн төлөө бригадынхан авто тээвэрчдийн улсын анхдугаар зөвлөлгөөнийг угтаж өндөр бүтээлийн 14 хоногийн ажил зарлан ажиллаж байна.

Тус социалист хөдөлмөрийн төлөө бригадын хамт олон авто тээвэрчдийн улсын зөвлөлгөөний өмнө 14 хоногт багтааж 2870 ширхэг гуалин тээвэрлэх үүргээ амжилттай биелүүлж аяны замдаа гарсан анхны өдөр 280 ширхэг гуалинг тээвэрлэж өдрийнхөө төлөвлөгөөг 130,4 хувиар биелүүллээ.

Энэ бол Жаргалантын сангийн аж ахуйн авто гараашийн Довдон ахлагчтай тээвэрчдийн социалист хөдөлмөрийн төлөө бригадынхан билээ.

*Ш. Ядамсүрэн*

Саяхан Өнжүүл сумын худалдаа бэлтгэлийн анги ХЗЭ—ийн хорооноос хамтран нохой агнах нэг өдөр зохиож 25 нохой агнав.

Энэ ажилд сумын анчин Ядам, МХЗЭ—ийн гишүүн Нямдаваа нар бусдаасаа идэвхтэй оролцсны дотроос анчин Ядамын мэргэн буудалтанд 12 нохой оногджээ.

*Б.Шагар*

## *Баярын хурал болов*

БНМАУ—ыг тунхагласны 40 жилийн ойд зориулсан баярын хурал аймгийн соёлын ордонд боллоо. Хурлыг аймгийн намын хорооны 2 дугаар нарийн бичгийн дарга Д. Дамбажамц нээж, аймгийн АДХ—ын Гүйцэтгэх захиргааны орлогч дарга Х.Сэтэв «БНМАУ—ыг тунхагласны 40 жилийн ой» гэсэн илтгэл тавилаа. Илтгэлд Октябрийн аугаа их хувьсгалын ялалтын дараа түүний хувьсгалжуулах нөлөөний дор манай ард түмэн капитализмын шатыг алгасан социализм байгуулж дуусгах шатандаа цэцэглэн хөгжиж яваа бөгөөд дэлхий дахины сая сая хөдөлмөрчдийн дунд түүхэн туршлага бүхий орон болон хөгжиж байгааг илтгэлд дэлгэрэнгүй дурьдаад, Манай аймгийн хөдөлмөрчид 1964 онд олсон амжилтаа улам бататган төлөвлөгөөт зүйлээ тоо, чанар үзүүлэлт бүрээр нь хугацааны нь өмнө давуулан биелүүлэхийг нийт хөдөлмөрчдөд уриаллаа.

Хурлын дараа хуралд оролцогчдод зориулан сайн дурын уран сайханчдын концерт тоглолоо.

*Ж. Төмөрсүх*